**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Увс аймаг дахь Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/55/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Р.Аюуш<br>Утас: 70453799, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ... 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ... 5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга ... 13
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ... 13
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ... 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ... 14
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ... 14
   3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ... 14
   3.5.1 Төсвийн төлөвлөлт ... 15
   3.5.2 Төсвийн гүйцэтгэл ... 15
   3.5.3 Нэмэлт төсөв ... 15
   3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ... 16
4. Аудитын тайлан ... 17
   4.1 Ерөнхий зүйл ... 17
   4.2 Материаллаг байдал ... 17
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт ... 18
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ... 18
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ... 18
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ... 19
5. Аудитын илрүүлэлт ... 19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ... 19


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |


УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400. Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.24 № УВА-2023/55/НА-СТА-ТШЗ
танай_____________-ны №______________-т

УВС АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С.ЦОЛМОН ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

## Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 417 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/103, А/104 дүгээр захирамжийн дагуу Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний эрүүл ахуйн хэлтсийг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт шилжүүлсэнтэй холбоотойгоор мэргэжилтнүүд ашиглаж байгаа үндсэн хөрөнгө, хангамжийн материалыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас шийдвэр гараагүй тул картаар хүлээлгэн өгч, 2022 оны санхүүгийн тайланд балансад бүртгэлтэйгээр тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/Төгрөг/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **272,287,017.03** | **109,720,008.03** |
| **33** | **АВЛАГА** | 12,500,000.00 | 17,200,731.00 |
| **335** | **Бусад авлага** | 12,500,000.00 | 17,200,731.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 12,500,000.00 | 7,200,731.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 7,200,000.00 | 39,550.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 7,200,000.00 | - |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | - | 39,550.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | - | 39,550.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 252,587,017.03 | 92,479,727.03 |
| **351** | **Түүхий эд материал** | 88,778,795.03 | 31,375,727.03 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 88,778,795.03 | 31,375,727.03 |
| **354** | **Хангамжийн материал** | 156,453,222.00 | 55,889,000.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 230,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 156,453,222.00 | 55,659,000.00 |
| 35600 | Мал амьтад | 7,355,000.00 | 5,215,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **534,962,598.16** | **613,169,727.68** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 534,962,598.16 | 613,169,727.68 |
| **392** | **Биет хөрөнгө** | 426,942,598.16 | 501,879,727.68 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 419,276,445.84 | 487,208,445.84 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (38,335,194.36) | (54,482,677.29) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 140,391,772.52 | 140,391,772.52 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (110,670,272.52) | (123,910,772.52) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 84,410,750.51 | 129,347,372.51 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (75,223,054.03) | (82,521,533.34) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 21,595,505.25 | 21,595,505.25 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (14,503,355.05) | (15,748,385.29) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17,910,999.20 | 17,910,999.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (17,910,999.20) | (17,910,999.20) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 108,020,000.00 | 111,290,000.00 |
| 39301 | Программ хангамж | 1,720,000.00 | 5,920,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (820,000.00) | (1,750,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 107,120,000.00 | 107,120,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **807,249,615.19** | **722,889,735.71** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **650,000.00** | **4,828,240.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 650,000.00 | 4,828240.00 |
| **413** | **Өглөг** | 650,000.00 | 4,828,240.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 3,538,040.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 650,000.00 | 1,290,200.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 200,000.00 | 1,283,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 450,000.00 | 7,200.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **806,599,615.19** | **718,061,495.71** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 806,599,615.19 | 718,061,495.71 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 790,071,309.76 | 790,071,309.76 |
| 51101 | Өмч: - төрийн | 790,071,309.76 | 790,071,309.76 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (246,975,988.88) | (335,514,108.36) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (246,975,988.88) | (246,975,988.88) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (88,538,119.48) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 263,504,294.31 | 263,504,294.31 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **807,249,615.19** | **722,889,735.71** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **555,102,516.22** | **578,376,197.75** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **69,846,679.80** | **167,355,703.75** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 69,846,679.80 | 167,355,703.75 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 69,846,679.80 | 167,355,703.75 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,355,465.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 63,491,214.80 | 167,355,703.75 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **485,255,836.42** | **411,020,494.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 394,447,300.00 | 374,902,684.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 394,447,300.00 | 374,902,684.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 90,808,536.42 | 36,117,810.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 77,360,000.00 | 4,193,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 808,536.42 | 7,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,640,000.00 | 24,924,810.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **500,710,934.76** | **464,193,445.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **500,710,934.76** | **464,193,445.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 443,756,919.01 | 406,716,582.59 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 220,827,754.67 | 241,491,059.92 |
| 210101 | Үндсэн цалин | 169,322,805.40 | 189,102,156.00 |
| 210102 | Нэмэгдэл | 46,412,573.20 | 41,734,906.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,092,376.07 | 10,653,997.92 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,558,326.00 | 30,395,130.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,567,916.08 | 20,848,754.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,247,502.48 | 2,414,944.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,798,081.98 | 1,901,715.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 449,620.50 | 475,428.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,495,204.96 | 4,754,287.25 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,570,541.00 | 34,241,880.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,430,647.00 | 3,517,087.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,304,320.00 | 28,617,004.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,835,574.00 | 2,107,789.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,134,406.00 | 23,929,610.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,090,490.00 | 2,076,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,095,532.00 | 16,259,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,435,584.00 | 2,487,360.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 455,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,057,800.00 | 3,106,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5.09 | 2,860,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5.09 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 2,860,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 815,700.00 | 1,199,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 815,700.00 | 1,199,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,128,000.00 | 4,896,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,128,000.00 | 4,896,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 82,336,684.00 | 18,643,410.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 77,538,496.00 | 9,017,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 632,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 178,200.00 | 643,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 281,408.00 | 38,010.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,928,000.00 | 7,875,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 355,580.00 | 382,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 53,385,502.25 | 49,060,492.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,928,179.87 | 7,330,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,590,000.00 | 2,869,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 31,867,322.38 | 38,861,492.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 56,954,015.75 | 57,476,862.89 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,402,000.00 | 29,827,984.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 26,967,984.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,402,000.00 | 2,860,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 54,552,015.75 | 27,648,878.89 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 54,552,015.75 | 27,648,878.89 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **54,391,581.46** | **114,182,752.27** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 188,329.02 | 202,720,871.75 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 188,329.02 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 202,720,871.75 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (188,329.02) | (202,720,871.75) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **54,203,252.44** | **(88,538,119.48)** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **476,906,301.42** | **406,319,763.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,150,465.00** | - |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,150,465.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,150,465.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,150,465.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **472,755,836.42** | **406,319,763.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 394,447,300.00 | 374,902,684.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 394,447,300.00 | 374,902,684.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 78,308,536.42 | 31,417,079.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 77,360,000.00 | 4,193,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 808,536.42 | 7,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 140,000.00 | 20,224,079.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **476,906,301.42** | **406,319,763.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **476,906,301.42** | **406,319,763.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **419,432,285.67** | **348,400,100.11** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 220,827,754.67 | 241,530,609.92 |
| 210101 | Үндсэн цалин | 169,322,805.40 | 189,141,706.00 |
| 210102 | Нэмэгдэл | 46,412,573.20 | 41,734,906.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,092,376.07 | 10,653,997.92 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,558,326.00 | 30,395,130.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,567,916.08 | 20,848,754.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,247,502.48 | 2,414,944.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,798,081.98 | 1,901,715.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 449,620.50 | 475,428.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,495,204.96 | 4,754,287.25 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,570,541.00 | 30,703,840.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,430,647.00 | 3,829,771.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,304,320.00 | 24,766,280.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,835,574.00 | 2,107,789.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,440,276.00 | 23,601,610.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,184,290.00 | 2,306,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,797,602.00 | 16,259,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,435,584.00 | 2,487,360.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 455,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,567,800.00 | 2,548,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 574,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 574,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,133,200.00 | 1,199,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,133,200.00 | 1,199,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,128,000.00 | 4,896,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,128,000.00 | 4,896,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 105,684,188.00 | 9,560,910.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 93,686,000.00 | 7,100,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 632,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 178,200.00 | 643,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 281,408.00 | 38,010.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 11,128,000.00 | 710,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 355,580.00 | 382,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,090,000.00 | 5,939,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,500,000.00 | 3,070,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,590,000.00 | 2,869,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **57,474,015.75** | **57,919,662.89** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,922,000.00 | 30,270,784.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 26,967,984.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,922,000.00 | 3,302,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 54,552,015.75 | 27,648,878.89 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 54,552,015.75 | 27,648,878.89 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 790,071,309.76 | 265,697,862.81 | -303,372,809.82 | 0.00 | 752,396,362.75 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 2,193,568.50 | 0.00 | 2,193,568.50 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **790,071,309.76** | **265,697,862.81** | **-301,179,241.32** | **0.00** | 754,589,931.25 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | -2,193,568.50 | 0.00 | 0.00 | -2,193,568.50 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **790,071,309.76** | **263,504,294.31** | **-301,179,241.32** | **0.00** | 752,396,362.75 |
| D01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **790,071,309.76** | **263,504,294.31** | **-301,179,241.32** | **0.00** | 752,396,362.75 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **790,071,309.76** | **263,504,294.31** | **-301,179,241.32** | **0.00** | 752,396,362.75 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -88,538,119.48 | 0.00 | -88,538,119.48 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **790,071,309.76** | **263,504,294.31** | **-389,717,360.80** | **0.00** | 663,858,243.27 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 374,902,700.00 | 367,477,884.11 | 7,424,815.89 | 98.0% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 374,902,700.00 | 367,477,884.11 | 7,424,815.89 | 98.0% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 346,171,900.00 | 337,807,100.11 | 8,364,799.89 | 97.6% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 250,155,200.00 | 241,530,609.92 | 8,624,590.08 | 96.6% |
| 210101 | Үндсэн цалин | 187,755,800.00 | 189,141,706.00 | (1,385,906.00) | 100.7% |
| 210102 | Нэмэгдэл | 52,104,900.00 | 41,734,906.00 | 10,369,994.00 | 80.1% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,294,500.00 | 10,653,997.92 | (359,497.92) | 103.5% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,644,400.00 | 30,395,130.19 | 249,269.81 | 99.2% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,838,200.00 | 20,848,754.00 | (10,554.00) | 100.1% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,451,600.00 | 2,414,944.47 | 36,655.53 | 98.5% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,961,200.00 | 1,901,715.59 | 59,484.41 | 97.0% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 490,300.00 | 475,428.88 | 14,871.12 | 97.0% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,903,100.00 | 4,754,287.25 | 148,812.75 | 97.0% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,791,600.00 | 30,703,840.00 | 87,760.00 | 99.7% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,976,000.00 | 3,829,771.00 | 146,229.00 | 96.3% |
| 210302 | Түлш, халаалт | 24,705,700.00 | 24,766,280.00 | (60,580.00) | 100.2% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,109,900.00 | 2,107,789.00 | 2,111.00 | 99.9% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,102,300.00 | 20,887,610.00 | 214,690.00 | 99.0% |
| 210401 | Бичиг хэрэг | 2,354,200.00 | 2,306,850.00 | 47,350.00 | 98.0% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,277,700.00 | 14,269,400.00 | 8,300.00 | 99.9% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,645,500.00 | 2,487,360.00 | 158,140.00 | 94.0% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,824,900.00 | 1,824,000.00 | 900.00 | 100.0% |
| **2105** | **Нормативт зардал** | 577,700.00 | 574,000.00 | 3,700.00 | 99.4% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 577,700.00 | 574,000.00 | 3,700.00 | 99.4% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,216,400.00 | 1,199,000.00 | 17,400.00 | 98.6% |
| 210604 | Урсгал засвар | 1,216,400.00 | 1,199,000.00 | 17,400.00 | 98.6% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,123,300.00 | 4,896,000.00 | 227,300.00 | 95.6% |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,123,300.00 | 4,896,000.00 | 227,300.00 | 95.6% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,561,000.00 | 6,560,910.00 | 90.00 | 100.0% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,100,000.00 | 4,100,000.00 | | 100.0% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 632,000.00 | 632,000.00 | | 100.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 643,500.00 | 643,500.00 | - | 100.0% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 38,100.00 | 38,010.00 | 90.00 | 99.8% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 | - | 100.0% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 710,000.00 | 710,000.00 | - | 100.0% |
| 210807 | Газрын төлбөр | 382,400.00 | 382,400.00 | - | 100.0% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 1,060,000.00 | (1,060,000.00) | #DIV/0! |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 1,060,000.00 | (1,060,000.00) | #DIV/0! |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 28,730,800.00 | 29,670,784.00 | (939,984.00) | 103.3% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,730,800.00 | 29,670,784.00 | (939,984.00) | 103.3% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,968,000.00 | 26,967,984.00 | 16.00 | 100.0% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,762,800.00 | 2,702,800.00 | (940,000.00) | 153.3% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 374,902,700.00 | 365,477,884.11 | 9,424,815.89 | 97.5% |
| **1320** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 374,902,700.00 | 365,477,884.11 | 9,424,815.89 | 97.5% |
| 122005 | Улсын төсвөөс | 374,902,700.00 | 365,477,884.11 | 9,424,815.89 | 97.5% |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1.00 | 0.00 | |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1.00 | 0.00 | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 20 | 18.00 | 2 | |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1.00 | 0.00 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11 | 9.00 | 2 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8.00 | 0.00 | |

**Нэмэлт төсвийн гүйцэтгэл**

**/төгрөг/**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Төлөв лөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | 11,193,000.00 | (11,193,000.00) |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 11,193,000.00 | (11,193,000.00) |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 10,593,000.00 | (10,593,000.00) |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 2,714,000.00 | (2,714,000.00) |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,990,000.00 | (1,990,000.00) |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 724,000.00 | (724,000.00) |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 3,000,000.00 | (3,000,000.00) |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 3,000,000.00 | (3,000,000.00) |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 4,879,000.00 | (4,879,000.00) |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 2,010,000.00 | (2,010,000.00) |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 2,869,000.00 | (2,869,000.00) |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | |
|---|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 600,000.00 | (600,000.00) |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 600,000.00 | (600,000.00) |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 600,000.00 | (600,000.00) |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 11,193,000.00 | (11,193,000.00) |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 11,193,000.00 | (11,193,000.00) |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 4,193,000.00 | (4,193,000.00) |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 7,000,000.00 | (7,000,000.00) |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр гарсан хууль, тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, хүн амыг эрүүл хүнсээр хангах, баталгаат байдлыг дээшлүүлснээр нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, малын чанар үүлдэр угсаа ашиг шимийг сайжруулан эрчимжсэн аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар салбарын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

- ✓ Малын генетик нөөцийн тухай хууль, Хүнсний тухай хууль, Органик хүнсний тухай хууль, Баяжуулсан хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Тариалангийн тухай хууль, Ургамал хамгааллын тухай хууль, Таримал үр сортын тухай хууль, Усны тухай хууль, Газрын тухай хууль, Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, Хоршооны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгал болон Татварын тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлэн мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
23
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

- ✓ Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 6 дугаарын сарын 02-ны өдрийн 120 дугаар "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,359.9 мянган төгрөгөөр буюу хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 19,700.0 | 17,240.3 | -2,459.7 |
| Бараа материал | 252,587.0 | 92,479.7 | -160,107.3 |
| Үндсэн хөрөнгө | 534,962.6 | 613,169.7 | 78,207.1 |
| **Нийт хөрөнгө** | **807,249.6** | **722,889.7** | **-84,359.9** |
| Өр төлбөр | 650.0 | 4,828.2 | 4,178.2 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 806,599.6 | 718,061.5 | -88,538.1 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **807,249.6** | **722,889.7** | **-84,359.9** |

Авлага дансны үлдэгдэл 2,459.7 мянган төгрөгөөр буурсан нь программын лицензийн төлбөр урьдчилж гарсан зардал 7,200.0 мянган төгрөгөөр барагдсан, акталсан трактор сэлбэгээр зарсан орлого 12,400.0 мянган төгрөг дансанд орсноор авлага буурсан. "Шинэ хөдөө-Увс" төслийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж хүнсний ногоо эрхлэгчдэд үнэгүй ногооны үр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

хуваарилсан зөвлөмж авсан ба буцаан 9,800.0 мянган төгрөг, хөдөө аж ахуйг дэмжих сангаас ирсэн ногооны үрийн 20 хувь буцаан авах нөхцөлтэйгөөр олгосон 7,440.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 160,107.3 мянган төгрөгөөр буурсан нь 2021 оны эцсийн санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн ба төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон үндсэн хөрөнгө эргэлтийн хөрөнгөд бүртгэснийг дотооддоо 100,794.2 мянган төгрөг хөрөнгө залруулж шилжүүлэн бүртгэсэн, 59,313.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж хуваарь хийсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө 78,207.1 мянган төгрөгийн цэвэр хөрөнгөөр нэмэгдсэн нь дотооддоо хөрөнгө шилжүүлэн авсан мөн ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалтаар 16,274.4 мянган төгрөгийн компьютер техник тоног төхөөрөмж авсантай холбоотой.

Өр төлбөр өмнөх оноос 4,178.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 12 дугаар сарын халаалтын төлбөр 3,538.0 төгрөг төлөгдөөгүй, Сама Увс ТВ-д 400.0 мянган төгрөг, МБС ТВ-ийн 520.0 мянган төгрөгийн гэрээний төлбөр, БҮТЭЗ-ийн зардал 370.2 мянган төгрөг төлөгдөөгүйтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 732,813.7 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 414,147.0 мянган төгрөгөөр бууруулж 318,666.7 мянган төгрөгөөр баталсан байна. 2022 оны төсвийн төслийг 414,147.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор 58,243.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 376,902.7 мянган төгрөгөөр баталсан байна.
Гүйцэтгэлээр улсын төсвөөс 376,902.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.
Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 374,902.7 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 2,000.0 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.
Гүйцэтгэлээр 4,060.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого бүрдүүлж, 29,719.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70805-Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага, 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 374,902.7 | 365,477.9 | 9,424.8 | 97.5% |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
23
ЗӨРЧИЛГҮЙ
СЛЕНЕЛ ДУГААР

Тайланд онд үндсэн үйл ажиллагааны зориулалтын цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 8,873.9 мянган төгрөг, дотоод албан томилолт болон бараа үйлчилгээний бусад зардлаас 550.9 мянган төгрөг, нийт 9424.8 мянган төгрөгийг хэмнэж улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгасан төсвөөс доод шатны төсвийн захирагчид 7,000.0 мянган төгрөгийн хоршооны хөгжлийг дэмжих, биржийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор сургалт зохион байгуулсан байна. Засаг даргын нөөцөөс 4,193.0 мянган төгрөгийн санхүүжилтээр хөдөө аж ахуйн мэргэжилтний зөвлөгөөнд зарцуулсан байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 70805-Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага, 82503-Эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг, тусламж үзүүлэх | 2022 он | 100% | 100% | 11,193.0 | 11,193.0 |

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 29 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 500,710.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,00.7 мянган төгрөгөөр тогтоосныг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 578,376.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,783.8 мянган төгрөгийн 80 хувиар буюу 4,627.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 143, хугацаа хоцроосон 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4,200.0 мянган төгрөгийн үнэ бүхий программ хангамжийг үндсэн хөрөнгийн дансанд, 8 нэр төрлийн 95,144.2 мянган төгрөгийн

хөрөнгийн эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн үнэн зөв бүртгэх гэсэн зөвлөмж өгсөн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 1 | 99,344.2 | 1 | 99,344.2 | 100% |
| **Нийт дүн** | 1 | 99,344.2 | 1 | 99,344.2 | 100% |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авлагыг анхаарах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | |
|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<u>АУДИТЫН ТАЙЛАНГ</u>

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Р.АЮУШ/

2022 оны 02 сарын 24-ний өдөр

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ